



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШУТИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/42/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Д.Ариунзаяа

Утас: 70373089 Цахим хаяг: AriunzayaD@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 56
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

ШУТИС-ийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 13-ны А/207 тоот тушаалаар “Санхүүгийн үйл ажиллагаа зохицуулах журам”-ыг шинэчлэн баталснаар сургууль хоорондын тооцоогоор урсгал санхүүжилтийг зогсоосноор санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2,175,528.9 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль нь тайлант онд Удирдах зөвлөлийн 5 дугаар тогтоолоор сургалтын төлбөрийн 1 кредитийн үнэлгээг нэмэгдүүлж, 12 дугаар тогтоолоор найдваргүй авлагыг хүчингүй болгосон байна.

4575028190

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль 2024 онд 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 79 зорилтод ажил төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувиар тайлагнасан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ШУТИС	Шинжлэх, ухаан, технологийн их сургууль

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,966,935,324.19	2,395,485,647.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,688,016,739.08	2,175,528,902.82
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,688,016,739.08	2,175,528,902.82
3121	Төгрөг	1,688,016,739.08	2,175,528,902.82
31213	Арилжааны банк дахь харилцах	1,688,016,739.08	2,175,528,902.82
33	АВЛАГА	258,126,440.75	199,095,383.42
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	236,372,420.20	189,816,483.42
335	Бусад авлага	21,754,020.55	9,278,900.00
3351	Байгууллагаас авах авлага	14,794,520.55	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,959,500.00	9,278,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	20,792,144.36	20,861,361.36
351	Түүхий эд материал	391,326.00	391,326.00
35130	Эм боох материал	391,326.00	391,326.00
354	Хангамжийн материал	20,400,818.36	20,470,035.36
35410	Бичиг хэргийн материал	118,293.00	154,440.00
35420	Аж ахуйн материал	8,882,500.00	9,035,000.00
35450	Барилгын засварын материал	5,223,213.92	5,106,983.92
35470	Бусад хангамжийн материал	6,176,811.44	6,173,611.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,782,357,457.99	15,823,685,627.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,782,357,457.99	15,823,685,627.73
391	Газар		
392	Биет хөрөнгө	13,852,844,524.32	13,894,997,627.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,821,626,093.20	15,121,626,093.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,737,865,912.82)	(2,090,060,696.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,630,000.00	41,630,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,874,444.46)	(40,255,000.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,168,485,413.79	1,125,643,415.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(775,374,629.05)	(657,078,052.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	360,341,152.29	393,569,319.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	(214,489,874.88)	(219,149,398.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,044,044.49	39,720,144.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,226,124.18)	(25,717,982.52)
39217	Ном	198,548,805.94	205,069,785.94
393	Биет бус хөрөнгө	1,929,512,933.67	1,928,688,000.00
39301	Програм хангамж	2,969,761.20	2,969,761.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,144,827.53)	(2,969,761.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,928,688,000.00	1,928,688,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,749,292,782.18	18,219,171,275.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,138,043,675.85	1,052,844,798.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,138,043,675.85	1,052,844,798.50
413	Өглөг	23,454,612.00	21,197,142.00
4136	Бусад өглөг	23,454,612.00	21,197,142.00
41361	Байгууллагад төлөх өглөг	736,648.00	736,578.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	22,717,964.00	20,460,564.00
414	Урьдчилж орсон орлого	1,114,589,063.85	1,031,647,656.50
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,058,288,150.85	1,031,647,656.50
	Бусад урьдчилж олсон орлого	56,300,913.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,611,249,106.33	17,166,326,476.83
51	Засгийн газрын хувь оролцоо	16,611,249,106.33	17,166,326,476.83

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,775,570,661.91	3,775,570,661.91
512	Хуримтлагдсан үр дүн	1,667,467,105.27	2,222,544,475.77
51210	Өмнөх үеийн үр дүн	928,079,269.76	1,667,467,105.27
51220	Тайлант үеийн үр дүн	739,387,835.51	555,077,370.50
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,168,211,339.15	11,168,211,339.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>17,749,292,782.18</u>	<u>18,219,171,275.33</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Тайлбар	Бүтэцтэй	Гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,501,688,533.01	6,064,361,083.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,498,097,633.01	5,986,602,029.43
120	Нийтлэг татварын бус орлого	6,481,213,173.01	5,575,412,949.43
120002	Хүүгийн орлого	23,017,685.27	49,223,405.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,449,726,538.74	5,515,665,543.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,378,769,833.90	4,956,184,938.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,070,956,704.84	559,480,605.07
120005	Түрээсийн орлого	6,372,000.00	10,524,000.00
120009	Бусад орлого	2,096,949.00	
122	Тусламжийн орлого	16,884,460.00	411,189,080.00
122001	Хандив тусламж /дотоод/	16,884,460.00	411,189,080.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,590,900.00	77,759,053.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,590,900.00	77,759,053.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		77,759,053.91
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих /Оюутны унааны хөнгөлөлт/	3,590,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,762,300,697.50	5,509,283,712.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,758,077,447.50	5,465,178,654.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,682,318,090.50	5,320,058,011.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,929,152,226.00	3,393,195,982.00
210101	Үндсэн цалин	2,436,132,209.00	2,909,915,491.00
210102	Нэмэгдэл	493,020,017.00	483,280,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,513,544.48	418,328,166.69
210201	Тэтгэврийн даатгал	250,949,277.98	286,013,311.69
210202	Тэтгэмжийн даатгал	30,277,584.05	33,649,459.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,031,870.45	18,104,848.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,614,149.00	14,716,004.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,640,663.00	65,844,544.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,066,213.76	190,186,105.99
210301	Гэрэл, цахилгаан	59,634,983.46	63,212,500.37
210302	Түлш, халаалт	107,864,722.50	76,121,350.90
210303	Цэвэр, бохир ус	42,566,507.80	50,852,254.72
2104	Хангамж, бараа материалын зардал	13,421,448.83	26,018,241.07
210401	Бичиг хэрэг	2,048,481.00	2,487,130.00
210402	Тээвэр, шатахуун	-	566,982.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,352,400.83	1,048,843.07
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,623,600.00	2,578,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,396,967.00	19,336,886.00
2105	Нормативт зардал	6,130,490.43	7,259,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	314,850.43	267,450.00
210502	Хоол, хүнс	5,815,640.00	6,992,322.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,573,548.00	131,311,803.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,250,500.00	7,324,043.00
210604	Урсгал засвар	52,323,048.00	123,987,760.00
2107	Томилолт, зочны зардал	5,844,873.00	19,002,484.00
210701	Гадаад албан томилолт		7,850,000.00
210702	Дотоод албан томилолт	5,817,623.00	8,646,022.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	27,250.00	2,506,462.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,323,387.84	117,122,552.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,980,563.69	103,182,541.59
210803	Даатгалын үйлчилгээ	232,020.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	576,020.00	250,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,044,170.00	13,407,971.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	402,614.15	226,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,994,292,358.16	1,017,632,904.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал /Сургууль хоорондын тооцоо/	1,216,838,181.50	334,685,006.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,017,340.99	49,044,166.75
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	722,436,835.67	633,903,730.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,759,357.00	145,120,643.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,759,357.00	145,120,643.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	600,000.00	1,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,961,900.00	130,832,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,197,457.00	13,088,043.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,223,250.00	44,105,058.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,223,250.00	44,105,058.00
225105	Бусад ашиг (алдагдал) /ТӨҮГ/ найдваргүй авлага	4,223,250.00	44,105,058.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	739,387,835.51	555,077,370.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	739,387,835.51	555,077,370.50

ХТД5430@9022899

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,943,831,076.29	5,668,855,568.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,940,240,176.29	5,591,096,514.62
120	Нийтлэг татварын бус орлого	6,940,240,176.29	5,591,096,514.62
120002	Хүүгийн орлого	8,223,164.72	64,017,926.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,791,463,060.80	5,008,045,357.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,791,463,060.80	5,008,045,357.21
120005	Түрээсийн орлого	15,417,000.00	15,887,100.00
120009	Бусад орлого /Сургууль хоорондын тооцоо+бусад/	3,125,136,950.77	503,146,130.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,590,900.00	77,759,053.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,590,900.00	77,759,053.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	77,759,053.91
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих /унаа хөнгөлөлт/	3,590,900.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,225,140,990.34	5,084,624,680.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,225,140,990.34	5,084,624,680.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,149,381,633.34	4,939,504,037.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,929,152,226.00	3,393,195,982.00
210101	Үндсэн цалин	2,436,132,209.00	2,909,915,491.00
210102	Нэмэгдэл	493,020,017.00	483,280,491.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,513,544.48	418,328,166.69
210201	Тэтгэврийн даатгал	250,949,277.98	286,013,311.69
210202	Тэтгэмжийн даатгал	30,277,584.05	33,649,459.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,031,870.45	18,104,848.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,614,149.00	14,716,004.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,640,663.00	65,844,544.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,066,143.76	190,186,175.99
210301	Гэрэл, цахилгаан	59,634,913.46	63,212,570.37
210302	Түлш, халаалт	107,864,722.50	76,121,350.90
210303	Цэвэр, бохир ус	42,566,507.80	50,852,254.72
2104	Хангамж, бараа материалын зардал	13,230,857.83	20,621,311.07
210401	Бичиг хэрэг	1,896,390.00	2,487,130.00
210402	Тээвэр, шатахуун	-	566,982.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,352,400.83	1,048,843.07
210404	Ном хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,623,600.00	2,578,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,358,467.00	13,939,956.00
2105	Нормативт зардал	6,130,490.43	7,259,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	314,850.43	267,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,815,640.00	6,992,322.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,165,458.00	97,753,603.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,250,500.00	7,324,043.00
210604	Урсгал засвар	44,914,958.00	90,429,560.00
2107	Томилолт, зочны зардал	5,817,623.00	19,002,484.00

X1034216-9021099

210701	Гадаад албан томилолт	-	7,850,000.00
210702	Дотоод албан томилолт	5,817,623.00	8,646,022.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		2,506,462.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	298,324,874.34	409,391,222.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,982,050.19	395,451,211.69
210803	Даатгалын үйлчилгээ	232,020.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	576,020.00	250,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,044,170.00	13,407,971.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	402,614.15	226,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,269,980,415.50	383,765,320.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,216,838,181.50	334,685,006.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,142,234.00	49,080,313.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,759,357.00	145,120,643.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,759,357.00	145,120,643.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	600,000.00	1,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,961,900.00	130,832,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,197,457.00	13,088,043.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,718,690,085.95</u>	<u>584,230,887.54</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	147,758,218.00	96,718,723.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,758,218.00	96,718,723.80
2200	Дотоод эх үүсвэрээр	147,758,218.00	96,718,723.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	147,758,218.00	96,718,723.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(147,758,218.00)</u>	<u>(96,718,723.80)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,570,931,867.95	487,512,163.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	117,084,871.13	1,688,016,739.08
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,688,016,739.08	2,175,528,902.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний мөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хөрөнгө/өмчийн өөрчлөлт
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,775,112,328.67	11,168,221,339.15	928,079,269.76	-	15,871,402,937.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,775,112,328.67	11,168,221,339.15	928,079,269.76	-	15,871,402,937.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	458,333.24	-	-	-	458,333.24
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	739,387,835.51	-	739,387,835.51
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,775,570,661.91	11,168,221,339.15	1,667,467,105.27	-	16,611,249,106.33
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,775,570,661.91	11,168,221,339.15	1,667,467,105.27	-	16,611,249,106.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,775,570,661.91	11,168,221,339.15	1,667,467,105.27	-	16,611,249,106.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Тайлант үеийн үр дүн	-	-	555,077,370.50	-	555,077,370.50
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,775,570,661.91	11,168,221,339.15	2,222,544,475.77	-	17,166,326,476.83

Handwritten signature and stamp area with a rectangular border. The stamp contains the text "ХТ0343009026893".

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/ Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,129,188,900.00	4,889,074,734.69	(240,114,165.3)	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,129,188,900.00	4,889,074,734.69	(240,114,165.3)	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,956,055,000.00	4,718,924,383.69	(237,130,616.3)	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,468,457,600.00	3,393,195,982.00	(75,261,618.0)	97.8
210101	Үндсэн цалин	2,661,685,000.00	2,629,701,665.00	(31,983,335.0)	98.8
210102	Нэмэгдэл	524,459,600.00	483,280,491.00	(41,179,109.0)	92.1
210105	Гэрээт ажлын хөлс	282,313,000.00	280,213,826.00	(2,099,174.0)	99.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	433,557,200.00	418,328,166.69	(15,229,033.3)	96.5
210201	Тэтгэврийн даатгал	294,818,896.00	286,013,311.69	(8,805,584.3)	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	34,684,576.00	33,649,459.00	(1,035,117.0)	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,747,660.80	18,104,848.00	(9,642,812.8)	65.2
210204	Ажилгүйдлийн даатгал	6,936,915.20	14,716,004.00	7,779,088.8	212.1
210205	Эрүүл мэндийн даатгал	69,369,152.00	65,844,544.00	(3,524,608.0)	94.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,000,000.00	190,186,175.99	(30,813,824.0)	86.1
210301	Гэрэл, цахилгаан	64,000,000.00	63,212,570.37	(787,429.6)	98.8
210302	Түлш, халаалт	98,000,000.00	76,121,350.90	(21,878,649.1)	77.7
210303	Цэвэр, бохир ус	59,000,000.00	50,852,254.72	(8,147,745.3)	86.2
2104	Хангамж, бараа материалын зардал	34,283,600.00	24,236,311.07	(10,047,288.9)	70.7
210401	Бичиг хэрэг	4,483,600.00	2,487,130.00	(1,996,470.0)	55.5
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	566,982.00	(1,933,018.0)	22.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.00	1,048,843.07	(2,451,156.9)	30.0
210404	Ном, хэвлэл	5,000,000.00	3,615,000.00	(1,385,000.0)	72.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,800,000.00	2,578,400.00	(1,221,600.0)	67.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,000.00	13,939,956.00	(1,060,044.0)	92.9
2105	Нормативт зардал	14,500,000.00	7,259,772.00	(7,240,228.0)	50.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00	267,450.00	(1,232,550.0)	17.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,000,000.00	6,992,322.00	(6,007,678.0)	53.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,400,000.00	108,936,103.00	(4,463,897.0)	96.1
210602	Тавилга	14,900,000.00	11,182,500.00	(3,717,500.0)	75.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000,000.00	7,324,043.00	(675,957.0)	91.6
210604	Урсгал засвар	90,500,000.00	90,429,560.00	(70,440.0)	99.9
2107	Томилолт, зочны зардал	27,834,000.00	19,002,484.00	(8,831,516.0)	68.3
210701	Гадаад албан томилолт	8,000,000.00	7,850,000.00	(150,000.0)	98.1
210702	Дотоод албан томилолт	17,134,000.00	8,646,022.00	(8,487,978.0)	50.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,700,000.00	2,506,462.00	(193,538.0)	92.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,300,000.00	43,417,221.59	(8,882,778.4)	83.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,400,000.00	42,885,181.59	(3,514,818.4)	92.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	0.00	(1,500,000.0)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	305,840.00	(494,160.0)	38.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	0.00	(3,000,000.0)	-

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	226,200.00	(373,800.0)	37.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	590,722,600.00	514,362,167.35	(76,360,432.7)	87.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	536,722,600.00	491,830,692.60	(44,891,907.4)	91.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,000,000.00	22,531,474.75	(31,468,525.3)	41.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,133,900.00	170,150,351.00	(2,983,549.0)	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,133,900.00	170,150,351.00	(2,983,549.0)	98.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	143,133,900.00	141,328,363.00	(1,805,537.0)	98.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	28,821,988.00	(1,178,012.0)	96.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,824,181,500.00	5,376,586,898.43	552,405,398.4	111.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	221,000,000.00	77,759,053.91	(143,240,946.1)	35.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	221,000,000.00	77,759,053.91	(143,240,946.1)	35.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,596,725,500.00	5,218,922,818.01	622,197,318.0	113.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,218,605,800.00	4,840,554,430.91	621,948,630.9	114.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	378,119,700.00	378,368,387.10	248,687.1	100.1
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	6,456,000.00	79,905,026.51	73,449,026.5	1,237.7
145005	Төсөв болон дамжуулан зээлүүлсэн зээлээс эргэн төлөгдөх	6,456,000.00	79,905,026.51	73,449,026.5	1,237.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,688,016,739.08	1,688,016,739.1	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,175,528,902.82	2,175,528,902.8	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
610001	Төсвийн байгууллага			-	
610002	Төсвөөс гадуур байгууллага	109.00	103.00	(6.0)	94.5
62	АЖИЛЛАГСДЫН ТОО			-	100.0
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	93.9
620002	Гүйцэтгэх ажилтан	66.00	62.00	(4.0)	94.7
620003	Үйлчлэх ажилтан	38.00	36.00	(2.0)	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль нь дээд боловсрол, эрдэм шинжилгээ судалгааны үйлчилгээ үзүүлдэг бөгөөд инженерийн дээд боловсролтой мэргэжилтний сургалт судалгааг олон улсын түвшинд хүргэхэд “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг баримтлан их сургуулийн үйл ажиллагааны зорилт төлөвлөлтийг чиглүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор баталсан “Их дээд сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 469,878.5 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,688,016.7	2,175,528.9	487,512.2
Авлага	258,126.4	199,095.4	(59,031.0)
Бараа материал	20,792.1	20,861.4	69.3
Үндсэн хөрөнгө	15,782,357.6	15,823,685.6	41,328.0
Нийт хөрөнгө	17,749,292.8	18,219,171.3	469,878.5
Өр төлбөр	1,138,043.7	1,052,844.8	(85,198.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,611,249.1	17,166,326.5	555,077.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,749,292.8	18,219,171.3	469,878.5

ШУТИС-ийн захирлын 2023 оны А/207 тоот тушаалаар “Санхүүгийн үйл ажиллагаа зохицуулах журам”-ын дагуу сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ өссөнөөр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 487,512.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага данс 59,031.0 мянган төгрөгөөр буурсан нь сургалтын төлбөрийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69.3 мянган төгрөгөөр өсөхөд, хандиваар 31,910.8 мянган төгрөгийн аж ахуйн засварын материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, өөрийн хөрөнгөөр 168,163.2 мянган төгрөгийн материал худалдан авсан, 200,004.7 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд сургалтын үйл ажиллагаатай холбоотой хангамжийн материал голлон үлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд 96,718.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар ирсэн 379,278.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, ТӨБЗГ-ын 2024 оны 631 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, дахин ашиглагдах боломжтой хөрөнгийг 199,234.8 мянган төгрөгөөр дахин үнэлж, ашиглах боломжгүй 30,552.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталжээ.

Орон нутагт суралцагчдын сургалтын төлбөрийн 469,200.0 мянган төгрөгийн хөнгөлөлт орж ирснээр урьдчилж орсон орлого буюу өр төлбөрийн данс 85,198.9 мянган төгрөгөөр буурчээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны зардлын төсвийн төсөлд нийт зарлагыг 4,781,618.6 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг 4,334,711.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дээд шатны төсвийн захирагч хэвээр баталсныг тайлант онд “Санхүүгийн үйл ажиллагаа зохицуулах журам”-ын дагуу дээд шатны төсөв захирагчид нийт зарлагыг 5,129,188.9 мянган төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг 4,824,181.5 мянган төгрөгөөр тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд зардлыг санхүүжүүлэхээр сургалтын төлбөрийн орлогоос 4,218,605.8 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 378,119.7 мянган төгрөг, түрээсийн

орлогоор 6,456.0 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтээр 221,000.0 мянган төгрөг, нийт 4,824,181.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр сургалтын төлбөрийн орлогоос 4,840,554.4 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 378,368.4 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтээс 77,759.0 мянган төгрөг, түрээсийн орлогоор 15,887.1 мянган төгрөг бусад эх үүсвэрээс 64,018.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, урсгал үйл ажиллагаанд 4,889,074.7 мянган төгрөгийг зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,175,528.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,889,074.7 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь 6 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 90,490.6 мянган төгрөгийг, хичээл практикийн зардлаас 31,468.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 44,891.9 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Тус байгууллага нь 100 хувь өөрийн орлогоос санхүүждэг тул төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 төсөл арга хэмжээний 55,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөө баталснаас гүйцэтгэлээр 50,801.0 мянган төгрөгийн гэрээг гүйцэтгэгчтэй байгуулж худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, үр дүнг мэдээлж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Д.Ариунзаяа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/19 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 3,794,455.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 37,944.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тээвэр шатахууны зардал гаргаагүй бөгөөд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 6,007.6 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 9,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын системийг эрчимжүүлэх

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны

сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Мэдээлэл хариуцагч хоорондоо албаны цахим шуудангаас бусад хэлбэрээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын системтэй холбогдож, ашиглана" Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолын 1-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны лиценз бүхий баримт бичиг боловсруулах программ хангамж ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй" Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын 5 дугаар хавсралт "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал"

Албан бичиг солилцооны DOCX дундын системийг ашиглаж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэж үйл ажиллагаандаа ашиглах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,897.8 мянган төгрөгийн 1 акт, 750.7 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг тулган шалгахад аудитын шийдвэрийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,897.8	1	2,897.8	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	750.7	1	750.7	100.0
Нийт дүн	1	3,648.5	1	3,648.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хууль, Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1 мэдээллийг байршуулаагүй байна.	1	9,000,000.0	-	-	-	-	1	9,000,000.0
Дүн	1	9,000,000.0	-	-	-	-	1	9,000,000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийн ДОСХ программ ашиглаагүй							1	
Дүн	-	-	-	-	-	-	1	-